

**Улаанбаатар хотын
Цэвэр агаарын санаачлага 2-р үе**

**Байгаль орчин, ногоон хөгжлийн яам/
Европын сэргээн босголтын банк**

**Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК**

2013-02-р сар



Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага 2-р үе

Гэрээний дугаар:22384/EBSF2009-09-117/01

“Цэвэр агаарын сан”-гийн үйл ажиллагаанд холбогдох хууль дүрмийг дагаж мөрдөх үйл ажиллагаа, зөрчлийг шийдвэрлэх арга зам сургалтын тайлан (ажлын даалгавар 3.4.17)

2013-02-р сар

Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
ЕСБХБ

БОНХЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
“One Exchange” Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл

| Шинэчилсэн | Огноо | Боловсруулсан | Шалгасан | Батласан | Тайлбар |
|------------|------------|-----------------------------|-----------------------|----------|---------|
| 1 | 2013-01-24 | Г.Сурахбаяр Б.Цэцэнбилэг | Д.Эрдэнэ Д. Энхээ, | | |
| | | | | | |

Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага төслийн 2-р үе

Улаанбаатар хотын гэр хороололд уламжлалт зууханд чанар муутай нүүрс түлэх нь ялангуяа өвлийн саруудад тус хотод бий болдог агаарын бохирдлын томоохон шалтгаан болдог. Улаанбаатар хотын агаарын чанарын доройтол нь хотын оршин суугчдын эрүүл мэнд цаашлаад улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Иймд уламжлалт зуухыг утаа бага ялгаруулдаг зуухаар солих, түүхий нүүрсийг боловсруулсан, нүүрсэн суурьтай, утаа бага ялгаруулдаг, илүү хэмнэлттэй түлшээр солих нь тус Улаанбаатар хотод тулгамдаад байгаа агаарын бохирдлын асуудлын нэлээд хэсгийг богино хугацаанд шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээний нэг гэж үзэх болсон. Боловсруулсан түлшний найдвартай хангалт, түлш, зуухыг хослуулах, тэдгээрийг дэмжсэн орчин, стандартуудыг гаргах нь уг арга хэмжээг үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай. Засгийн Газар орлуулах түлшний үйл ажиллагааны тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэхийг Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-наас хүссэн юм. ЕСБХБ нь Засгийн Газартай 2008 оны 9-р сараас түүхий нүүрсийг боловсруулсан түлшээр орлуулах төлөвлөгөөг боловсруулахаар хамтран ажиллаж эхэлсэн. Уг төлөвлөгөөний гол хэсгүүдийг 2009 оны 6-р сард Засгийн Газраар батлуулахаар өргөн барьсан Түлш орлуулах үйл ажиллагааны ерөнхий хүрээнд тусгасан. Засгийн газар Үйл ажиллагааны хүрээ гол бүрэлдэхүүн хэсгүүдийг зарчмын хувьд баталж, 2010 оны 6-р сард Монгол Улсын Их хурал Агаарын багц хуулиудыг батласаны дараа тус банк төслийн II үеийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болж Үйл ажиллагааны үйл ажиллагааны ерөнхий хүрээ гол хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх Зөвлөхүүдийг шалгаруулж авах ажлыг гүйцэтгэсэн. Зөвлөхүүд нь Үйл ажиллагааны ерөнхий хүрээ холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт хууль эрх зүй, эдийн засаг, техникийн болон чадавхийг бэхжүүлэх шаардлагатай тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой.

Энэхүү баримт бичгийг дээр нэр заасан төслийн зорилгоор, зөвхөн ашиглах эрх бүхий талуудад зориулан гаргасан болно. Энэхүү баримт бичгийг өөр бусад талууд өөр зорилгоор ашиглаж үл болно.

Энэхүү баримт бичгийг ашиглах эрх бүхий талуудаас бусад этгээдүүд өөр зорилгоор ашигласнаас үүдэн гарсан үр дагавар, бусад талуудаас нийлүүлсэн мэдээллийн алдаа мадаг, орхигдсон зүйлсийн талаар манай тал ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү баримт бичиг нь нууц мэдээлэл агуулсан оюуны өмчийн бүтээл болно. Бидний болон энэ баримтыг бэлтгэсэн талын зөвшөөрөлгүйгээр бусад талуудад үзүүлэхийг хориглоно.

*Агаары бохирдлыг бууруулах чиглэлээр ажилладаг хандивлагч
байгууллагуудын уулзалтын тайлан*



Гарчиг

| | |
|---|-----------|
| 1. СУРГАЛТЫН ЗОРИЛГО | 8 |
| 2. СУРГАЛТЫН БЭЛТГЭЛ АЖИЛ | 8 |
| 3. СУРГАЛТЫН АГУУЛГА | 2 |
| 3.1. ЗӨРЧЛИЙГ ТОДОРХОЙЛОХ СЭДВИЙН ХҮРЭЭНД..... | 2 |
| 3.2. ГАРСАН ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ СЭДВИЙН ХҮРЭЭНД | 2 |
| 3.3. ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД СЭДВИЙН ХҮРЭЭНД:..... | 3 |
| 3.4. ДАСГАЛ АЖИЛЛУУЛАХ:..... | 3 |
| 4. ДҮГНЭЛТ | 3 |
| ЭРҮҮГИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖ БҮХИЙ АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ..... | 5 |
| <i>Эрүүгийн хэргийг шийдвэрлүүлэх</i> | 5 |
| <i>Хэргийг хянан шийдвэрлэх хугацаа, үе шат</i> | 6 |
| ИРГЭНИЙ ХЭРЭГ МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ. | 6 |
| <i>Шүүх хэргийг хянан шийдвэрлэх</i> | 7 |
| <i>Шүүхийн шийдвэрийг биелүүлэх.....</i> | 7 |
| ЗАХИРГААНЫ ХЭРЭГ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ..... | 7 |
| <i>Захиргааны хэрэг маргааны тухай ойлголт</i> | 7 |
| <i>Шүүх хэргийг шийдвэрлэх</i> | 9 |
| БУСАД ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛЛАГА АЛБАН ТУШААЛТАН | 9 |
| <i>Захиргааны зөрчлийг шийдвэрлэх</i> | 9 |
| ХАВСРАЛТ -3 ДААЛГАВАР | 23 |

Хавсралт

| | |
|--|----|
| ХАВСРАЛТ 1: СУРГАЛТАД ОРОЛЦОГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ..... | 5 |
| ХАВСРАЛТ 2: СУРГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА..... | 11 |

Товчилсон үгийн тайлбар

ЦАС

Цэвэр агаарын сан

УБЦАС-II

Улаанбаатарын цэвэр агаарын санаачлага-2

1. Сургалтын зорилго

Улаанбаатар хотын Цэвэр агаарын санаачлага-2 төслийн хүрээнд ажлийн даалгаврын 3.4.17-д заасны дагуу доорхи үднсэн гурван ажлыг гүйцэтгэх үүрэгтэй. Үүнд :

1. Зөвлөх баг нь хууль/тогтоомжийн зөрчлийн талаарх гомдол ба бодит жишээг судлах тал дээр ЦАС нэг бүрчлэн дэмжлэг үзүүлж, сургалт явуулна. (шаардлагатай тохиолдолд бусад төрийн байгууллагуудтай хамтарна).
2. Зөвлөх баг нь энэ төрлийн судалгаа явуулах ЦАС-гийн холбогдох ажилтныг дагаж мөрдөх горимын багцыг багтаасан гарын авлага/горимын зарчмаар хангах байдлаар дадлагажуулна.
3. Энэ ажлын дараагаар хэрэгжилтийг нарийвчлан тайлбарласан товч тайлан боловсруулна.

Энэхүү ажлын хүрээнд зохих бэлтгэлийг ханган сургалтийг 2013 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан бөгөөд сургалтад ЦАС-гийн холбогдох ажилтан, албан хаагчид оролцов. Сургалтыг төслийн хуулийн мэргэжилтэн Б.Цэцэнбилэг удирдан явуулав.

2. Сургалтын бэлтгэл ажил

Сургалтын бэлтгэл ажлын хүрээнд сургалтын агуулгыг оновчтой болгох, ЦАС-д бий болж байгаа бодит хүндрэл бэрхшээл дээр тулгуурлан сургалтыг зохион байгуулах зорилгоор ЦАС-гийн хуулийн зөвлөхтэй цуврал уулзалт зохион байгуулж хамтран ажиллаж сургалтын ерөнхий агуулгыг тодорхойлсон болно. Түүнчлэн ЦАС-нгийн удирдлагатай сургалтыг явуулах цаг хугацаа, оролцогчдыг тодорхойлох зэрэг асуудлаар зөвлөлдсөн билээ.

Сургалтын хэрэгцээг тодорхойлсны дагуу:

- Зөрчлийн талаар хууль эрх зүйн ойлголт өгөх
- Ийнхүү ойлголт өгөхдөө схемчилсэн хэлбэрээр сургалтын танилцуулгыг бэлтгэх
- Тодорхой асуудлыг шийдвэрлэх дадлага олгохын тулд дасгал ажиллуулах

зэрэг агуулгын дагуу энэхүү сургалтын явуулахаар харилцан тохиролцсон бөгөөд мөн сургалтын материалын урьдчилан ЦАС-гийн удирдлагад танилцуулж, нарийвчлан ярилцаж зохих зөвлөмж, саналуудыг аван сайжруулсны үндсэн дээр сургалтын материалыг эцэслэн боловсруулж бэлтгэсэн.

3. Сургалтын агуулга.

Дээр дурьдсанчлан сургалт нь зөрчлийг тодорхойлох, гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам, зөрчил шийдвэрлэх арга хэлбэр, эрх бүхий этгээд гэсэн үндсэн гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдсэн ба доор эдгээр сэдвүүдийг товч тайлбарласан ба дэлгэрэнгүй сургалтын гарын авлагыг нэгдүгээр хавсралтанд оруулсан болно.

3.1. Зөрчлийг тодорхойлох сэдвийн хүрээнд

Эрх зүйн ойлголтын хувьд зөрчил гэдэг нь юу болох, зөрчлийг хэрхэн ангиллах, зохицуулж байгаа хууль эрх зүйн талаар ерөнхий ойлголт өгсөн болно.

Зөрчлийн талаарх ойлголыг тайлбарлахдаа Эрүүгийн гэмт хэрэг, Иргэний болон Захиргааны эрх зүйн хүрээнд тус бүр зөрчлийг хэрхэн ойлгож хуульчилан, эдгээр зөрчлүүдийг хооронд хэрхэн ялгах талаар авч үзэж тодорхой ойлголтуудыг өгөхийг зорьсон юм.

3.2. Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам сэдвийн хүрээнд

Энэхүү сэдвийн хүрээнд эрүүгийн гэмт хэрэг, мөн Иргэний Захиргааны зөрчлүүд гарсан, энэ талаар ЦАС-д мэдээлэл, өргөдөл гомдол ирсэн тохиолдолд уг зөрчлийг хэрхэн шийдвэрлэх, хаана хандах, эрх бүхий байгууллага ямар хуулийн үндсэн дээр хэд хоногийн дотор шийдвэрлэх талаар ерөнхий ойлголтыг өгөхийг зорьсон болно.

Өөрөөр хэлбэл:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үе шатууд,

- Хэрэг бүртгэлт мөрдөн байцаах
- Прокурорын хяналт
- Шүүх хэргийг шийдвэрлэх

Иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

- Нэхэмжлэл гаргах
- Нэхэмжлэлд тавигдах шаардлага
- Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
- Шийдвэр гүйцэтгэл

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

- Дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах журам
- Шүүхэд нэхэмжлэл гаргах
- Шүүх хэргийг шийдвэрлэх

Захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх

- Захиргааны зөрчлийн талаарх ойлголт

- Зөрчлийг хянан шийдвэрлэх этгээд зэрэг мэдээллийг сургалтын явцад өгөхийг зорьсон болно.

3.3. Зөрчлийг шийдвэрлэх эрх бүхий этгээд сэдвийн хүрээнд:

Ямар зөрчлийг, ямар эрх бүхий этгээд шийдвэрлэх, эрх бүхий этгээдийн зөрчлийг шийдвэрлэх эрх хэмжээ, тухайн зөрчилд ямар хариуцлага тооцох талаарх ерөнхий ойлголтыг өгсөн болно.

3.4. Дасгал ажиллуулах:

Сургалтын хүрээнд сургалтад оролцогчдын авсан мэдээллийг бататгах, амьдралд хэрэгжүүлэхэд илүү ойлгомжтой болоход чиглэгдсэн хоёр дасгалыг сургалтад ороцогчдоор ажиллуулсан юм. /Дасгалын нөхцөлийг Хавсралт-3 оруулсан болно./

Энэхүү дасгал ажиллах явцад ЦАС-д тулгарч байгаа асуудлууд, гарсан зөрчил, шийдвэрлэгдсэн маргааны талаар оролцогчидттой ярилцаж тодорхой зөвлөгөөг өгсөн.

4. Дүгнэлт

“Цэвэр агаарын сан” нь агаарыг хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулагч бодисын дэгдэлтийг бууруулах үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх ба энэ чиглэлийн үйл ажиллагаанд зориулан тус сангаас санхүүжүүлсэн хөрөнгийг оновчтой, үр ашигтай зарцуулах зорилготойгоор¹ үүсгэн байгуулагдсан байгууллага билээ.

ЦАС нь үүсэн байгуулагдсанаас хойш тус санд иргэдээс ихэвчлэн санхүүжилт хүссэн, мөн хууль цаасан урамшуулал олгуулах талаар болон утаагүй зуух хөнгөлөлттэй авах талаар өргөдлүүд голчон ирдэг юм байна.

Иргэдээс ирсэн 2 өргөдлийг үзэхэд уг өргөдлүүд нь цахилгаан халаагуур ашгласан боловч урамшуулал авах боломжгүй болсон иргэдийн өргөдөл байсан юм.

Өргөдлийн агуулга нь өргөдөл гаргасан иргэд цахилгаан халаагуур тавьсан боловч хатуу түлшний зуух давхар хэрэглэж байгаа гэсэн шалтгаанаар цахилгааны урамшуулал авч чадаагүй талаар байлаа. Тиймээс энэхүү асуудлыг ЦАС-гаар шийдвэрлүүлэхээр иргэд өргөдөл гаргажээ. ЦАС нь тодорхой төслийг санхүүжүүлэх үүрэгтэй байгууллага бөгөөд урамшуулал олгох эсэх асуудлыг шийдвэрлэх эрх хэмжээг хуулиар тодорхойлоогүй байгаа юм.

ЦАС-д ирж байгаа өргөдөл, хүсэлтийг дийлэнх нь тус сан шийдвэрлэх эрх хэмжээний асуудал биш мөн харьяаллын бус асуудлыг тавьж байгаа нь иргэд ЦАС-гийн талаарх ойлголт муу байгаатай холбоотой. Иймээс ЦАС-ын талаар, түүний чиг үүрэг, эрх хэмжээний талаарх мэдээллийг иргэдэд хүргэх нь нэн чухал байна.

Гарсан зөрчлийн талаар гэвэл ЦАС нь түлш үйлдвэрлэгч компанийг иргэний журмаар шүүхэд өгч хэргийг шийдвэрлүүлсэн туршлага байна. Ийнхүү туршлага дээр

¹ Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан “Цэвэр агаарын сан”-гийн дүрэм

үндэслэн гэрээний үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагуудыг шүүхэд өгч зөрчлийг арилгуулах боломжтой юм.

Хавсралт

Хавсралт 1: Сургалтын гарын авлага

Зөрчлийг тодорхойлох

Зөрчил гэдэгт:

Хүчин төгөлдөр хууль тогоомжууд болон бусад хууль тогтоомжуудын хүрээнд хууль болон гэрээ, холбогдох дүрэм заавар хэрэгжүүлээгүй эсхүл зөрчсөн, үйлдэл эс үйлдэхүйг:

Үйлдэл гэдэгт

Хүний идэвхтэй

Эс үйлдэхүй

Хүний идэвхгүй үйлдлийг тус тус ойлгоно.

Эрүүгийн гэмт хэргийн шинж бүхий асуудлыг шийдвэрлэхэд баримтлах журам.

Гэмт хэргийг тодорхойлох шинж нь:

Тухайн зөрчил гаргасан этгээдийн үйлдэл, эс үйлдэл Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байгаа эсэхийг тодорхойлох

Нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл эс үйлдэл байх эсэхийг тодорхойлох шаардлагатай бөгөөд дээрх шинж байвал гэмт хэрэг гэж үзнэ.

Эрүүгийн хэргийг шийдвэрлүүлэх

Хэрэв “Цэвэр агаарын сан”-гийн хувьд бусдын хууль бус үйлдлийн улмаас хохирол учирсан, ийнхүү хохирол учруулсан этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжтэй тохиолдолд гэмт хэргийн талаархи мэдээллийг бичгээр өгөх бөгөөд түүнд холбогдох баримт, материалыг хавсаргаж болно.

Мэдээллийг Авилгалтай тэмцэх газар, Тагнуулын төв газар, Цагдаагийн байгууллага, Прокурорын дэргэдэх мөрдөн байцаах алба зэрэг хэрэг бүртгэл мөрдөн байцаалт явуулдаг эрх бүхий байгууллагуудад бичгээр гэмт хэргийн талаар гомдол гарган шийдвэрлүүлнэ.

Хэрэв гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ.

Иргэний нэхэмжлэлийг эрүүгийн хэргийг үүсгэснээс эхлэн шүүхийн хэлэлцүүлэг хүртэлх шатанд гаргаж болно.

Хэргийг хянан шийдвэрлэх хугацаа, үе шат

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа, прокурорын хяналт, шүүхийн ажиллагаа байдаг. Эдгээр ажиллагаа тус бүр хуульд заасан хугацаанд хэрэгжих бөгөөд хэргийг шүүх эцэслэн шийдвэрлэнэ.

Иргэний хэрэг маргааныг шийдвэрлэхэд баримтлах журам.

Нэхэмжлэлийн хэлбэр

Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргах бөгөөд нэхэмжлэгч, эсхүл түүнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж буй этгээд гарын үсгээ зурсан байх шаардлагатай.

Нэхэмжлэлийн бүрдүүлбэр

Шүүхэд гаргаж байгаа нэхэмжлэл нь доорх бүрдүүлбэрийг хангасан байх шаардлагатай.

- нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа;
- нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;
- хариуцагчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;
- нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт;
- нэхэмжлэлийн үнэ;
- хавсаргасан баримт бичгийн жагсаалт.
- Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх тухай хүсэлт, хэрэв нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг мөн хавсаргана.
- Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.
- Нэхэмжлэлийг шүүхэд гаргах, хүлээн авах

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авсаны дараа нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байгаа эсэхийг хянана.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэлүүдийг тодорхойлсон байдаг.

Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй байвал иргэний хэрэг үүсгэж мөн хэрэг үүсэх тухай захирамж гаргана.

Шүүх хэргийг хянан шийдвэрлэх

Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

Шүүхийн шийдвэрийг биелүүлэх

Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсоны дараа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь зохицуулагддаг.

Захиргааны хэрэг маргаан шийдвэрлэх

Захиргааны хэрэг маргааны тухай ойлголт

Дараахь байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ:

- Монгол Улсын Засгийн газрын гишүүн /Ерөнхий сайд, сайд/;
- Монгол Улсын яам;
- Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг;
- Төрийн албаны Зөвлөл, түүний салбар байгууллага;
- Монголбанк;
- Санхүүгийн зохицуулах хороо;
- яамны харьяа болон харьяа бус захиргааны акт гаргадаг бие даасан агентлаг, түүнтэй адилтгах газар, зөвлөл, товчоо, төв, сан зэрэг байгууллага;
- аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;
- аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг /хэлтэс, газар/;
- улсын хяналт шалгалтын болон захиргааны хяналтын байгууллага, тэдгээрийн хянан шалгагч, байцаагч, цагдаагийн, тагнуулын, хилийн цэргийн байгууллага, түүний захиргааны таслан зогсоох болон шийтгэлийн арга хэмжээ авах эрх бүхий бүх албан тушаалтан;
- аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн нийтийн Хурал, тэдгээрийн Тэргүүлэгчид;
- төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг болон холбоо, харилцаа, эрчим хүчний системийн захиргаа зэрэг үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг байгууллага;

- сүм хийдийн захиргаа;
- шийдвэр, үйл ажиллагааг нь захиргааны хэргийн шүүхэд давж гомдол гаргаж байхаар хуульд тусгайлан заасан нийтийн эрх зүйн субъект болох бусад байгууллага, албан тушаалтан.

Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах

Хэрэв захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус акт нь байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтныг шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргана.

Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан 30 хоногийн дотор хянан шийдвэрлэж хариу өгнө. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор сунгаж болно. Хугацаа сунгасан тухай гомдол гаргасан иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэнэ.

Шүүхэд нэхэмжлэл гаргах

Иргэн, хуулийн этгээд дараахь тохиолдолд холбогдох захиргааны актыг хүлээн авснаас, эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй:

Нэхэмжлэлийн бүрдүүлбэр

Нэхэмжлэлийг шүүхэд бичгээр гаргах бөгөөд нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсхүл түүнийг захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлж байгаа этгээд гарын үсэг зурсан байна.

Нэхэмжлэлд дараахь зүйлийг тусгана:

- Нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шүүхэд гаргаж байгаа;
- Нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол нэр, оршин байгаа газрын хаяг;
- Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл;
- Хавсаргасан баримт бичгийн жагсаалт.
- Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, түүнчлэн нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг хавсаргана.
- Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө.
- Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл гэдэгт дараахь зүйл багтана:
- Захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны хууль бус актын улмаас нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн;

- Захиргааны хэргийн шүүхээс ямар шийдвэр гаргуулж зөрчигдсэн эрхээ хэрхэн сэргээлгэхийг хүсэж байгаа, түүний үндэслэл;
- Захиргааны хууль бус актын улмаас ямар хохирол учирсан, түүнийг хэрхэн шийдвэрлүүлэх.

...талаар нэхэмжлэлийн шаардлагад тодорхой дурьдсан байна.

Шүүх хэргийг шийдвэрлэх

Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан, эсхүл нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангаж ирүүлсэн өдрөөс хойш 7 хоногийн дотор захиргааны хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

Хуулиар тусгайлан хугацаа тогтоогоогүй бол захиргааны хэргийн шүүх хэрэг үүсгэснээс хойш 60 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

Захиргааны зөрчлийг шийдвэрлэх

Захиргааны зөрчлийн тухай ойлголт

Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журам санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил байдаг.

Зөрчил гаргасан этгээдэд дараахь захиргааны шийтгэл ногдуулж болдог.

- торгох;
- тусгайлан олгосон эрх хасах /тээврийн хэрэгсэл жолоодох;
- хууль бусаар олсон орлого, эд зүйл буюу зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, байрыг хураах;
- баривчлах.
- Захиргааны хариуцлага хүлээлгэх эрх бүхий этгээд
- Дараахь албан тушаалтан энэ хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэх бүрэн эрхийг эдэлнэ:
- шүүгч;
- сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга;
- цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан;
- хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах ;

- хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч;
- хорих ангийн дарга, жинхэнэ гүйцэтгэх ажилтан;
- консулын эрх бүхий албан тушаалтан;
- төрийн тусгай хамгаалалтын газрын гадуур хамгаалалтын алба хаагч, харуулын захирал;
- хуульд тусгайлан заасан тохиолдолд байгаль хамгаалагч;
- нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч.
- хуульд тусгайлан заасан тохиолдолд аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга
- Зөрчлийг хянан шийдвэрлэх

Зөрчлийг хянан шалгах эрх бүхий албан тушаалтан зөрчлийн тухай гомдол, мэдээлэл, үйл баримтыг үндэслэн зөрчлийг хянан шалгах ажиллагааг 14 хоногийн дотор явуулна.

Дээр хугацаанд зөрчлийг хянан шалгах ажиллагааг дуусгах боломжгүй бол уг хугацааг тухайн эрх бүхий байгууллагын удирдлагын шийдвэрээр 14 хүртэл хоногоор сунгаж болно.

Зөрчлийг хянан шалгах ажиллагаанд зөрчлийн тухай тэмдэглэл хөтлөх, үзлэг шинжилгээ хийх шаардлагатай эд зүйл, баримт бичгийг түр хураах, зөрчил гаргасан этгээдэд таслан сэргийлэх арга хэмжээ авах, албадан саатуулах ажиллагаа хамаарна.

Хавсралт 2: Сургалтын танилцуулга

Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага II үе ТӨСӨЛ:

**“Цэвэр агаарын сан”-гийн үйл
ажиллагаанд холбогдох хууль дүрмийг
дагаж мөрдөх үйл ажиллагаа, зөрчлийг
шийдвэрлэх арга зам**

Хэрэгжүүлэгч:
Евроконсалт Мотт МакДоналд

Туслан гүйцэтгэгч:
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК (MBS хуулийн фирм)

Улаанбаатар хот
2013 он

Сургалтын зорилго, хамрах хүрээ

- Улаанбаатар хотын Цэвэр агаар санаачлага II төслийн ажлын даалгаврын 3.4.16 хүрээнд энэхүү 2 тайлан бэлтгэгдсэн болно:
 - ✓ Зөрчлийг тодорхойлох
 - ✓ Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам
 - ✓ Зөрчил шийдвэрлэх арга хэлбэр, эрх бүхий этгээд



Зөрчлийг тодорхойлох

➤ “Цэвэр агаарын сан”-гийн үйл ажиллагааны хэлбэр

- Засгийн газрын тусгай сангийн хувьд хуульд заасан журмын дагуу санхүүжүүлэх;
- Гэрээний нэг тал болон харилцаанд оролцох;
- Сангийн дотоод үйл ажиллагаантай холбоотой харилцаа гэх мэт харилцаанд ордог.

Эдгээр харилцаанд оролцоход ямар нэгэн ЗӨРЧИЛ илэрсэн тохиолдолд хэрхэн шийдвэрлэх талаар авч үзнэ.

Зөрчлийг тодорхойлох

Зөрчил гэдэгт:

Хүчин төгөлдөр хууль
тогоомжууд хууль
болон гэрээ, холбогдох
дүрэм заавар хэрэгжүүлээгүй эсхүл
зөрчсөн, үйлдэл эс үйлдэхүйг:

Үйлдэл гэдэгт:

- Хүний идэвхтэй

Эс үйлдэхүй:

- Хүний идэвхгүй



Зөрчлийг тодорхойлох


Зөрчил
маргаан

Иргэний хэрэг

Эрүүгийн хэрэг


Захиргааны
хэрэг

Зөрчлийг тодорхойлох



Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

- Эрүүгийн хэргийг шийдвэрлэх



Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

Хэрэв гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, эсхүл түүний учруулсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг хариуцвал зохих этгээдэд холбогдуулан иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй бөгөөд тэрхүү нэхэмжлэлийг шүүх уг хэргийн хамт хянан шийдвэрлэнэ



Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

- Эрүүгийн хэрэг шийдвэрлэх явц

Хэрэг
бүртгэлт
Мөрдөн
байцаалт

Прокурорын
хяналт

Шүүх

Зөрчлийг тодорхойлох

- Иргэний хэргийн ойлголт

Эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаа

Гэрээний маргаан

Гэм хор

Зөрчлийг тодорхойлох

Гэрээний маргаан

- Талуудын хооронд байгуулсан гэрээний үүрэгтэй холбогдох маргаан

Гэм хор

- Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй. /Иргэний хуулийн 497.1.-р зүйл/

Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

- Гэрээ гэдэг нь
- Талууд харилцан эрх,
 - үүрэг үүсгэх, өөрчилөх
 - дуусгавар болгохоор
 - хийгдсэн хэлцэл



Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

- Гэрээний маргаанд юу шаардаж болох вэ?
 - Гэрээний үүргийг зохих ёсоор биелүүлэхийг
 - Гэрээний үүргээ хугацаандаа биелүүлээгүйгээс үүссэн үр дагавар
 - Гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас учирсан хохирол

Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

- Гэм хор учруулсан тохиодолд юу шаардаж болох вэ?
 - Эд хөрөнгийн хохирол
 - Нэр хүнд сэргээлгэх
 - Эрүүл мэндэд учирсан хохирол

Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

- Иргэний хэрэг хянан шийдвэрлэх



Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

Нэхэмжлэл гаргах:

Нэхэмжлэл гаргахад шаардагдах бүрдүүлбэр:

- нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа;
- нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;
- хариуцагчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;
- нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт;
- нэхэмжлэлийн үнэ;
- хавсаргасан баримт бичгийн жагсаалт.
- Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх тухай хүсэлт, хэрэв нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг мөн хавсаргана.



Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

- Улсын тэмдэгтийн хуваармж төлөх

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-д төсвийн байгууллагын нэхэмжлэлийг тэмдэгтийн хураамжаас чөлөөлөхөөр заасан.

Тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээ

| Нэхэмжлэлийн үнийн дүн /төгрөгөөр/ | Хураамжийн хувь, хэмжээ /төгрөгөөр/ |
|------------------------------------|--|
| 0-130 000 | 4550 төгрөг. |
| 130 001-650 000 | 4550 төгрөг дээр 130 000 төгрөгөөс давсан дүнгийн 3 хувийг нэмнэ. |
| 650 001-1 300 000 | 20150 төгрөг дээр 650 000 төгрөгөөс давсан дүнгийн 2.4 хувийг нэмнэ. |
| 1 300 001-13 000 000 | 35750 төгрөг дээр 1 300 000 төгрөгөөс давсан дүнгийн 1.6 хувийг нэмнэ. |
| 13 000 001-ээс дээш | 222950 төгрөг дээр 13 000 000 төгрөгөөс давсан дүнгийн 0.5 хувийг нэмнэ. |

Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

- [Нэхэмжлэлийг хаана гаргах](#)
- Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана.
- Хариуцагч нь хуулийн этгээд байвал нэхэмжлэлийг түүний ажил хэргээ байнга явуулдаг, эсхүл удирдах байгууллага нь байгаа газрын шүүхэд гаргана. Хэрэв хариуцагчийн оршин суугаа газар мэдэгдэхгүй байвал нэхэмжлэлийг эд хөрөнгө нь байгаа газрын шүүхэд гаргаж болдог.
- Бусдын амь бие, эрүүл мэндэд гэм хор учруулсны хохирлыг нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг хариуцагч, эсхүл нэхэмжлэгчийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно. Гэрээнд үүрэг гүйцэтгэх газрыг тусгайлан заасан бол түүнтэй холбогдсон нэхэмжлэлийг уг гэрээг биелүүлбэл зохих газрын шүүхэд гаргаж болно. Өөр өөр газар оршин суугаа /оршин байгаа/ хэд хэдэн хариуцагчид холбогдох нэхэмжлэлийг нэхэмжлэгч өөрийн үзэмжээр хариуцагчдын аль нэгний оршин суугаа /оршин байгаа/ газрын шүүхэд гаргана.
- Эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох тухай нэхэмжлэлийг иргэн, хуулийн этгээд өөрийн оршин суугаа /оршин байгаа/ газрын, эсхүл тухайн үйл явдал болсон газрын шүүхэд гаргана.

Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

- Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.



Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

Захиргааны хэргийн тухай

Захиргааны акт

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын харьяа байгууллага | УИХ-аас удирдлага нь томилогддог хараат бус агентлагууд | Нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага | Хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр нийтлэг үйлчилгээ үзүүлдэг байгууллага |
| Яам, агентлагууд яамны харьяа болон харьяа бус захиргааны акт гаргадаг бие даасан агентлаг, түүнтэй адилтгах газар, зөвлөл, товчоо, төв, сан зэрэг байгууллага; | Монгол банк, Үнэт цаасны хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Төрийн албаны зөвлөл, Үндэсний статистикийн газар, Үндэсний аудитын газар, Хүний эрхийн Үндэсний комисс | Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга; Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг /хэлтэс, газар/; | Төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг болон холбоо, харилцаа, эрчим хүчний системийн захиргаа зэрэг үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг байгууллага; |

Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

Захиргааны акт

- Захиргааны байгууллага албан тушаалтан гаргасан
- Захирамжилсан шинжтэй
- Эрх зүйн үр дагавар үүсгэх
- Гадагш чиглэсэн байх


Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам

• Юу шаардаж болох вэ?

- Захиргааны актын хүчингүй болгох
- Захиргааны актыг илт хүчин төгөлдөр бусад тооцуулах
- Даалгах нэхэмжлэл



Гарсан зөрчлийг шийдвэрлэх арга зам



Хавсралт -3 Даалгавар

БОДЛОГО-1

Байгаль орчин ногоон хөгжлийн яам түүхий нүүрс түлэхийг хориглосон шийдвэр гаргажээ.

Иргэн Н уг шийдвэрийг өөрийг эрх ашгийг хохироосон гэж үзэж нэхэмжлэл гаргах болсон байна.

Иргэн Н:

Уг маргаан нь ямар маргаан болохыг тодорхойлох?

Ямар шүүхэд хандах?

Хэрэв хамаарах бол иргэн Н ямар төрлийн нэхэмжлэлийг гаргах боломжтой вэ?

БОДЛОГО-2

А компани цэвэр түлш үйлдвэрлэхээр захиалагчтай гэрээ байгуулжээ.

Цэвэр агаарын сан санхүүжүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд төлбөрийг бүрэн шилжүүлсэн байна.

Гэтэл А компани гэрээнд заасан хэмжээнд түлшийг үйлдвэрлэж чадаагүй бөгөөд дутуу үйлдвэрлэсэн, мөн түлш нь чанарын шаардлагад нийцээгүй гэсэн дүгнэлт гарчээ.

ЦАС ямар арга хэмжээ авах вэ?

1. Ямар эрх зүйн маргаан бэ?
2. Ямар шүүхэд хандах вэ?
3. Юу шаардаж болох вэ?

